



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 27 өдөр

Дугаар A/225

Мандалговь

Г Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-н "а", 29.1.6-н "а", "г", "л" дахь заалт, 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 7, 32 .1.12 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 178, 183, 2016 оны 153 дугаар тогтоолын 3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын улмаас улсын хэмжээнд "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэнтэй холбогдуулан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бизнесийн тогтвортой байдал, ажлын байрыг хадгалах зорилгоор "Сум хөгжүүлэх сан"-гийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан "Хэвийн зээлийн ангилал"-тай байгаа зээлдэгчдээс төлбөр хойшлуулах хүсэлт ирүүлсэн нөхцөлд үндсэн зээлийн болон хүүгийн төлбөрийн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 1-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулж хуваарьт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр."Хэвийн зээл"-ийн ангилалаас бусад ангилалд буюу хугацаа хэтрэлттэй зээлдэгч төлөлт хийж төлбөрийн аливаа зөрчилгүй "хэвийн зээл"-ийн ангилалд шилжсэн нөхцөлд 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зээлийн төлбөрийг хойшлуулахыг мэдээлж ажиллахыг мэргэжилтэн (Ш.Бямба)-д үүрэг болгосугай.

Гурав. Зээлийн эргэн төлөлтийн хугацааг тушаалын 1-д заасан төлбөр хойшлуулах хугацаагаар нэмэгдүүлж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг мэргэжилтэн (Ш.Бямба), ня-бо (О.Бямбасүрэн) нарт-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГОХ